



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 8/128

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар хуралдааны "Аймгийн 2017 оны төсөв батлах тухай" 02 дугаар тогтоол, №ЗТ-04/2017 дугаартай "Өндөрхаан нисэх буудлын барилга байгууламж, аэродромыг шинээр барих ажлын ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн инженерийн баримт бичгийн орчуулгын ажлыг гүйцэтгэх гэрээ"-ний 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өндөрхаан нисэх буудлын зураг төслийн баримт бичгийг орчуулахтай холбогдуулан хөрөнгө зарцуулсугай.
2. Орчуулгын ажилд шаардагдах 2000000 /хоёр сая/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн "2017, 2018 онд хийгдэх ажлуудын зураг төсөв, геологийн зардал"-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 628